



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2017 ОНЫ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



[www.nso.mn](http://www.nso.mn) [govisumber.nso.mn](http://govisumber.nso.mn) [www.1212.mn](http://www.1212.mn)

## 1. ХҮН АМ, ӨРХ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

**1.1.** 2017 оны жилийн эцсийн байдлаар манай аймаг 17399 хүн, үүнээс эрэгтэй 8723, эмэгтэй 8676 хүнтэй боллоо. Өмнөх онтой харьцуулбал хүн ам 465 буюу 2.7 хувиар, үүнээс эрэгтэй 240 буюу 2.9 хувиар, эмэгтэй 218 буюу 2.6 хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа. Нийт хүн амын 50.1 хувийг эрэгтэйчүүд, 49.9 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Нийт хүн амыг яс үндсээр нь танилцуулбал 96.7 хувь нь халх, 1.0 хувь нь дөрвөд, 1.0 хувь нь баяд, 0.5 хувь нь казах үндэстэн байна.

Нийт хүн амын 34.1 хувийг 0-15 насны хүүхэд, 60.3 хувийг 16-59 насны хүмүүс, 5.6 хувийг 60 ба түүнээс дээш насны хүмүүс эзэлж байна. Насны бүлгээс харахад 70 ба түүнээс дээш настан 369, 80 ба түүнээс дээш настан 114, 90 ба түүнээс дээш настан 18 тоологдлоо. Дээрх үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулбал 70 ба түүнээс дээш настан 0.8 хувиар, 80 ба түүнээс дээш настан 15.2 хувиар, 90 ба түүнээс дээш настан 12.5 хувиар тус тус өссөн байна.

Манай аймгийн иргэдээс гадаадад 6 ба түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа 186 иргэн бүртгэгдсэн бөгөөд тэдгээрийн 88 буюу 47.3 хувь нь эрэгтэйчүүд, 98 буюу 52.7 хувь нь эмэгтэйчүүд байна. Өмнөх онтой харьцуулбал гадаадад суугаа иргэд 19.2 хувиар, үүнээс эрэгтэйчүүд 14.3 хувиар, эмэгтэйчүүд 24.1 хувиар тус тус өссөн үзүүлэлт гарлаа.

Тайлант онд 5364 өрх тоологдсон нь өмнөх оноос 175 өрхөөр буюу 3.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт өрхөөс 3151 буюу 58.7 хувь нь аймгийн төвд, 949 буюу 17.7 хувь нь сумын төвд, 1264 өрх буюу 23.6 хувь нь хөдөөд байршиж байгаа бөгөөд нийт өрхөөс 10 буюу түүнээс дээш ам бүлтэй өрх 15 тоологдлоо. Нийт өрхийн 59.8 хувь нь байшинд, 40.2 хувь нь гэрт амьдарч байна.

**1.2.** 2017 онд хөдөлмөрийн насны хүн ам 10343, үүнээс 5855 нь ажиллагчид байгаа нь хөдөлмөрийн насны хүн амын 56.6 хувийг эзэлж байна. Аймгийн хэмжээнд нийт 5967 хүн хөдөлмөр эрхэлж байгаагийн 0.9 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна. Өмнөх онтой харьцуулбал хөдөлмөрийн насны хүн ам 0.7 хувиар өсч, хөдөлмөрийн насны ажил эрхлэгч 0.2 хувиар буурсан үзүүлэлт гарчээ.

Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 2017 оны 12 сард 284 байгаагийн 167 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.8 хувиар өссөн, харин 26 ажлын байрны захиалга ирсэн нь өмнөх оны мөн үеэс 5.8 дахин, 16 иргэн ажилд зуучлуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 3.1 дахин буурсан байна.

Тайлант онд Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газраас давхардсан тоогоор 5634 хүнд 1378.2 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, халамж үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад үйлчилгээ авсан иргэдийн тоо 910 буюу 19.3 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтийн хэмжээ 118.5 сая төгрөг буюу 9.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

**1.3.** 2017 оны жилийн эцсийн байдлаар иргэний бүртгэлийн мэдээгээр аймгийн хэмжээнд 394 эхээс 400 хүүхэд мэндэлсний 211 нь хүү, 189 нь охин байлаа. Нийт 100 хүн нас барсан байна. Бүртгүүлсэн гэр бүл 72, цуцалсан гэр бүл 34, үрчлэгдсэн хүүхэд 7 бүртгэгдлээ. Өмнөх онтой харьцуулахад төрөлт 65 буюу 14.2 хувиар, төрсөн хүүхэд 65 буюу 14.0 хувиар,

нас баралт 15 буюу 13.0 хувиар, бүртгүүлсэн гэр бүл 9 буюу 11.1 хувиар тус тус буурсан бол цуцалсан гэр бүл 14 буюу 70.0 хувиар өсч, үрчлэгдсэн хүүхэд өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна.

Шилжин ирсэн хүн 641 байгаа нь өмнөх оны мөн үеэс 104 хүн буюу 14.0 хувиар буурч, шилжин явсан хүн 488 болж өмнөх оны мөн үеэс 199 хүн буюу 29.0 хувиар буурсан байна. Шилжин ирэгчдийн 230 буюу 35.9 хувь нь Улаанбаатар хотоос, 101 буюу 15.8 хувь нь Дорноговь аймгаас, 81 буюу 12.6 хувь нь Дундговь аймгаас ирсэн байна. Шилжин явагчдын 101 буюу 20.7 хувь нь Улаанбаатар хот руу, 116 буюу 23.8 хувь нь Дорноговь аймаг руу, 71 буюу 14.5 хувь нь Дундговь аймаг руу шилжин явсан байна.

**1.4.** Багуудаас гаргасан мэдээллээр аймгийн хэмжээнд бүтэн өнчин хүүхэд 21, үүнээс эмэгтэй 9, хагас өнчин хүүхэд 184, үүнээс эмэгтэй 93 байгаа нь өмнөх оны мөн үеэс бүтэн өнчин хүүхэд 3 буюу 12.5 хувиар, хагас өнчин хүүхэд 1 буюу 0.5 хувиар буурсан байна. Өрх толгойлсон эцэг, эх 779 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна. Ганц бие өндөр настан 270 байгаа нь өмнөх оны мөн үеэс 7 буюу 2.5 хувиар буурч, хөгжлийн бэрхшээлтэй иргэд 688 байгаа нь өмнөх оны мөн үеэс 5 буюу 0.7 хувиар өсчээ.

Хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн зарим үзүүлэлтийг тайлант оны байдлаар авч үзвэл: (Тайлант онд амьжиргааны доод түвшин төвийн бүсэд 166200 төгрөг)

Ядуу өрх 367, өрхийн гишүүд 1561 байгаа нь нийт өрхийн 6.4 хувийг, нийт хүн амын 9.0 хувийг эзэлж байгаа бөгөөд өрх болон хүн амд эзлэх хувийг өмнөх онтой харьцуулбал 0.1-0.5 пунктээр буурсан үзүүлэлт гарлаа.

## **2. МАЛ ТООЛЛОГО, ХӨДӨӨ АЖ АХУЙ**

**2.1.** 2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр аймгийн хэмжээнд 1041 малтай өрх тоологдсоноос 712 малчин өрх, 329 малтай өрх тоологдлоо. Малчин өрхөд 2371 хүн амьдарч байгаагаас 1164 малчин, үүнээс 509 нь эмэгтэй малчид байна.

Нийт малчдыг насны бүлгээр нь авч үзвэл :

15-34 нас - 364 малчин буюу 31.4 хувь

35-59 нас - 644 малчин буюу 55.4 хувь

60 аас дээш нас - 154 малчин буюу 13.2 хувийг эзэлж байна.

Өмнөх онтой харьцуулбал малтай өрх 14 буюу 1.3 хувиар, малчин өрх 9 буюу 1.2 хувиар, мал бүхий өрх 5 буюу 1.5 хувиар тус тус цөөрсөн байна. Малчдын тоог өмнөх онтой харьцуулбал 67 буюу 5.4 хувиар үүнээс эмэгтэй малчид 49 буюу 8.8 хувиар буурлаа. Тайлант онд манай аймагт нэг мянгаас дээш толгой мал тоолуулсан 100 малтай иргэн бүртгэгдсэнээс 99 нь малчин байгаа нь өмнөх оны мөн үеэс 11 буюу 12.5 хувиар нэмэгдлээ. Үүнд:

Сүмбэр сумын мянгат малчин 68

Баянтал сумын мянгат малчин 19

Шивээговь сумын мянгат малчин 12

Хамгийн олон малтай малчин Г.Мөнхбаяр

/Баянтал сумын 1 дүгээр баг, 3095 толгой мал/,

Хамгийн олон адуутай малчин Л.Батнасан

/Баянтал сумын 2 дугаар баг, 399 толгой мал/,

Хамгийн олон үхэртэй малчин М.Батсайхан

/Сүмбэр сумын 4 дүгээр баг, 338 толгой мал/,

Хамгийн олон тэмээтэй малчин Б.Төмөрмөнх

/Шивээговь сумын 2 дугаар баг, 88 толгой мал/,

Хамгийн олон хоньтой малчин Г.Мөнхбаяр

/Баянтал сумын 1 дүгээр баг, 1949 толгой мал/,

Хамгийн олон ямаатай малчин Ц.Нэргүй

/Шивээговь сумын 2 дугаар баг, 1347 толгой мал/

	Малтай өрхийн малын бүлэглэлт	Малчин өрхийн малын бүлэглэлт
10 хүртэл толгой малтай	24	6
11-30 толгой малтай	54	13
31-50 толгой малтай	63	22
51-100 толгой малтай	85	33
101-200 толгой малтай	184	99
201-500 толгой малтай	322	243
501-999 толгой малтай	209	197
1000-1499 толгой малтай	68	67
1500-2000 толгой малтай	18	18
2001 түүнээс дээш толгой малтай	14	14

**2.2.** 2017 оны жилийн эцсээр манай аймаг 438.4 мянган толгой малтай болсон нь өмнөх оны мөн үеэс 58.9 мянган толгой буюу 15.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс: адуу 22271 толгой, үхэр 14903 толгой, тэмээ 929 толгой, хонь 205229 толгой, ямаа 195077 толгой тус тус тоологджээ. Аймгийн хэмжээнд төллөвөл зохих эх малын 92.4 хувь буюу 171461 толгой мал төллөж, гарсан төл 173054, үүнээс 2828 төл хорогдож, 170226 төл бойжиж төл бойжилт 98.4 хувьтай гарлаа. Оны эцэст 201.5 мянган толгой хээлтэгч мал байгаа нь өмнөх оны мөн үеэс 15.9 мянган толгой буюу 8.6 хувиар өсчээ.

2016 онд 7308 төл хорогдсон бол 2017 онд 2828 төл хорогдож өмнөх оны мөн үеэс 4480 буюу 61.3 хувиар буурсан ба нийт хорогдсон төлийн 53.9 хувийг ишиг, 44.5 хувийг хурга эзэлж байна. Жилийн эцсийн байдлаар 2890 том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үеэс 11.8 мянгаар буюу 5.1 дахин буурсан байна.

**2.3.** Эрлийз, цэвэр үүлдэр, сайжруулсан омгийн мал 12448, үүнээс “Сүмбэр” хонь 1497 толгой тоологдлоо. Энэ нь өмнөх онтой харьцуулбал эрлийз, цэвэр үүлдрийн мал 9.4 хувиар, “Сүмбэр” хонь 5.9 хувиар тус тус буурсан байна.

Нийт малд эрлийз, цэвэр үүлдэр, сайжруулсан омгийн мал 2.8 хувийг эзэлж байгаа бол эрлийз, цэвэр үүлдэр, сайжруулсан омгийн адуу 90 тоологдсон нь нийт адууны 0.4 хувийг, эрлийз, цэвэр үүлдэр, сайжруулсан омгийн үхэр 736 тоологдсон нь нийт үхрийн 4.9 хувийг, эрлийз, цэвэр үүлдэр, сайжруулсан омгийн тэмээ 21 тоологдсон нь нийт тэмээний 2.3 хувийг, эрлийз, цэвэр үүлдэр, сайжруулсан омгийн хонь 7911 тоологдсон нь нийт хонины 3.9 хувийг, эрлийз, цэвэр үүлдэр, сайжруулсан омгийн ямаа 3690 тоологдсон нь нийт ямааны 1.9 хувийг тус тус эзэлж байна.

**2.4.** Хүн ам, мал, хөдөө аж ахуйн тэжээвэр амьтдын 2017 оны тооллогоор аймгийн дүнгээр гахай, шувуу 3237 тоологдсон нь өмнөх оны мөн үеэс 20.5 хувиар буурчээ.

Нийт 241 гахай, үүнээс:

Хээлтэгч	86	
Хээлтүүлэгч	17	
Бусад		138

Нийт 2996 шувуу, үүнээс:

Үндсэн эх	2846	
Хээлтүүлэгч	147	
Бусад		3

Өмнөх онтой харьцуулахад гахай 36 буюу 13.0 хувиар, шувуу 797 буюу 21.0 хувиар буурсан байна.

**2.5** 2017 онд 38.7 га талбайд тариалалт хийснээс төмс 17.2 га-д, хүнсний ногоо 17.2 га-д, тэжээлийн ургамал 4.3 га-д тариалсан байна. Өмнөх онтой харьцуулбал нийт тариалсан талбай 13.0 га буюу 25.1 хувиар буурснаас төмсний талбай 5.7 га буюу 24.9 хувиар, хүнсний ногооны талбай 1 га буюу 5.5 хувиар, тэжээлийн ургамлын талбай 6.3 га буюу 59.4 хувиар тус тус буурсан байна.

Ургац хураалтын эцсийн мэдээгээр аймгийн хэмжээнд 269.1 тонн төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал хурааснаас 100.6 тонн төмс, 140.7 тонн хүнсний ногоо, 27.8 тонн тэжээлийн ургамал хурааж авсан нь өмнөх оны мөн үеэс 48.9 тонноор буюу 22.2 хувиар, үүнээс төмс 2.9 тонн буюу 3 хувиар, хүнсний ногоо 23.3 тонн буюу 19.8 хувиар, тэжээлийн ургамал 22.7 тонн буюу 5.5 дахин өссөн байна.

2017 онд малчид 2969.1 тонн өвс, 18.1 тонн дарш, 628.1 тонн хужир шүү бэлтгэж авсныг өмнөх онтой харьцуулбал бэлтгэсэн өвс 77.5 хувиар, бэлтгэсэн хужир 90.5 дахин, хужир шүү 66.6 хувиар нэмэгдсэн байна.

### **3. АЖ ҮЙЛДВЭР**

**3.1** 2017 онд 52.2 тэр бум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 54.1 тэр бум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна. Өмнөх онтой харьцуулбал бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 10.7 хувиар өссөн ба үүнд уул, уурхайн салбарын үйлдвэрлэлт голлон нөлөөлсөн байна. Бүтээгдэхүүн борлуулалт өмнөх оны мөн үеэс 20.6 хувиар өслөө.

“Шивээ-Овоо” ХК нь тайлант онд 46.9 тэр бум төгрөгийн нүүрс үйлдвэрлэж, 49.2 тэр бум төгрөгийн борлуулалт хийсэн байна. Эдгээр үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулбал бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 3.9 хувиар, бүтээгдэхүүн борлуулалт 15.1 хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа. Тус компани нь аймгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 89.8 хувийг, нийт борлуулалтын 90.9 хувийг гүйцэтгэсэн бөгөөд зах зээл дээр 1 тонн нүүрсийг 27380 төгрөгөөр худалдаалж байна.

**3.2** Аймгийн хэмжээний төв суурин газруудад халаалт, халуун хүйтэн ус үйлдвэрлэх, бохир ус татан зайлуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд тайлант онд нийт 2376.1 сая төгрөгийн үйлдвэрлэл явуулсан нь өмнөх онтой харьцуулбал нийт үйлдвэрлэл 21.7 хувиар, Чойр кашмер, Чойр хайрхан, Шивээсервис зэрэг боловсруулах үйлдвэрлэл явуулж буй аж ахуйн нэгжүүд 2950.9 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 28.4 дахин нэмэгдлээ.

#### **4. ТӨСӨВ САНХҮҮ, БАНК, ОРОН НУТГИЙН ӨМЧ**

**4.1** 2017 оны байдлаар орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 14718.3 сая төгрөг, гүйцэтгэл 15304.4 сая төгрөг болж орлогын төлөвлөгөө 104.0 хувийн биелэлттэй байна. Төсвийн орлогыг задаргаагаар нь авч үзвэл урсгал орлого урсгал орлого 13.2 хувиар даван биелэсэн үзүүлэлт гарлаа.

Төсвийн зарлага 16809.6 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 14712.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 12.5 хувийн хэмнэлттэй гарлаа. Нийт зардлыг задаргаагаар нь авч үзвэл хөрөнгийн зардал 25.8, урсгал зардал 10.3 хувийн хэмнэлттэй гарсан байна.

Төсөвт байгууллагын өглөг, авлагын мэдээгээр өглөгийн үлдэгдэл 9.6 сая төгрөг, авлагын үлдэгдэл 18.5 сая төгрөг болсон нь өмнөх оны мөн үеэс өглөг 65.6 хувиар буурч, авлага 50.4 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

**4.2.** Говьсүмбэр аймагт үйл ажиллагаа явуулж буй банкуудын салбарын эдийн засгийн үзүүлэлтийг 2017 оны эцсийн байдлаар танилцуулбал цахим банкны үйлчилгээ хэрэглэгчид 30.7 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 39.0 хувиар, зээл авсан аж ахуйн нэгж 50.0 хувиар, иргэд 6.9 хувиар, аж ахуйн нэгжид олгосон зээлийн хэмжээ 1.5 хувиар, иргэдэд олгосон зээлийн хэмжээ 22.6 хувиар өссөн бөгөөд АТМ-н тоо хоёроор нэмэгдсэн бол зээлийн бүтээгдэхүүн 17.3 хувиар, зээл авсан малчид 11.5 хувиар, малчдад олгосон зээлийн хэмжээ 45.4 хувиар буурсан байна.

**4.3.** Орон нутгийн өмчийн газрын мэдээгээр манай аймаг 2017 онд 73 бараа, үйлчилгээг 3063.5 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 72 тендер зарлагдаж, 2808.5 төгрөгийн бараа, үйлчилгээ гэрээлэгдсэн байна. Өмнөх онтой харьцуулбал төлөвлөгдсөн бараа, үйлчилгээ 43.1 хувиар, төсөв 48.2 хувиар, зарлагдсан тендер 41.2 хувиар, гэрээлэгдсэн төсөв 53.3 хувиар тус тус өссөн байна.

## **5. НИЙГМИЙН ДААТГАЛ, БУСАД ДААТГАЛУУД**

**5.1** Нийгмийн даатгалын сангийн орлого 2017 оны 12 дугаар сарын байдлаар 12133.6 сая төгрөг, зарлага 11257.7 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс орлого 4549.9 сая төгрөг буюу 13.4 хувиар, зарлага 1872.4 сая төгрөг буюу 9.1 хувиар тус тус өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн орлого 7.0 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 23.8 хувиар, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 20.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага өсөхөд тэтгэврийн сангийн зарлага 10.3 хувиар, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 13.2 хувиар, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 9.3 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

**5.2** Говьсүмбэр аймагт үйл ажиллагаа явуулдаг даатгалын компаниудын тайлант оны мэдээллээс танилцуулахад нийт орлого 210.2 сая төгрөг, олгосон нөхөн төлбөр 48.5 сая төгрөгт хүрснийг өмнөх онтой харьцуулбал орлого 0.9 хувиар, олгосон нөхөн төлбөр 29.4 хувиар буурсан байна. Орлого буурахад гэнэтийн ослын болон жолоочийн хариуцлагын даатгалын орлого буурсан нь нөлөөлсөн бол олгосон нөхөн төлбөр буурахад тээврийн хэрэгслийн даатгалын нөхөн төлбөр огцом буурсан нь нөлөөлжээ. Тайлант оны хувьд хөдөлмөрийн чалвар түр алдалтын даатгалын нөхөн төлбөр, хүүхдийн гэнэтийн ослын даатгалын нөхөн төлбөрүүд нь орлогоосоо давсан үзүүлэлттэй байна.

## **6. ТЭЭВЭР, ХОЛБОО, ГАЗАР**

**6.1** Авто тээврийн үндэсний төвийн Говьсүмбэр аймаг дахь салбарын мэдээгээр тайлант онд 25.3 мянган зорчигч тээвэрлэж, зорчигч эргэлт 5456.6 мян.хүн км болж, 11 ажилтантай 15.4 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх онтой харьцуулбал зорчигч тээвэрлэлт 6.0 хувиар, зорчигч эргэлт 1.9 хувиар, тээврийн орлого 8.7 хувиар тус тус өссөн үзүүлэлт гарлаа.

2017 оны байдлаар 3505 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 15.0 хувиар өссөн байна. Тээврийн хэрэгслийг төрлөөр нь өмнөх онтой харьцуулбал суудлын авто машин 21.4 хувиар, 2 дугуйт 30.0 хувиар, бусад төрлийн тээврийн хэрэгсэл 16.9 хувиар өсч, ачааны автомашин 2.5 хувиар, буурсан үзүүлэлттэй байна.

**6.2** Аймгийн холбооны газрын мэдээгээр 2017 онд нийт орлого 156.2 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 46.2 сая төг буюу 22.8 хувиар буурчээ. Нийт орлогод хүн амаас орсон орлого 93.7 сая төг буюу 60.0 хувийг эзэлж, өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна. Аймгийн хэмжээнд нийт суурин телефон цэгийн тоо 285 болж өмнөх оны мөн үеэс 49 буюу 14.7 хувиар, КТВ суваг 866 болж өмнөх оны мөн үеэс 367 буюу 29.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2017 онд интернет үйлчилгээний цэгийн тоо 2, үйлчлүүлэгчийн тоо 432 үүнээс байнгын хэрэглэгчийн тоо 15 байна. Тайлант онд 105 цахилгаан мэдээ гарсан нь өмнөх оны мөн үеэс 3 дахин өссөн байна.

**6.3** Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын мэдээгээр манай аймгийн нийт газар нутгийн хэмжээ 554.2 мян.га байдаг бөгөөд нийт талбайн:

376819 га буюу 68.0 хувийг Сүмбэр сум

91606 га буюу 16.5 хувийг Баянтал сум

85755 га буюу 15.5 хувийг Шивээговь сум эзэлж байна.

2017 онд нийт газрын:

481186.6 га буюу 86.8 хувийг - Хөдөө аж ахуйн газар

6537.2 га буюу 1.2 хувийг - Хот, тосгон, суурин газар

5256.4 га буюу 0.9 хувийг - Зам шугам сүлжээний газар

1538.0 га буюу 0.3 хувийг - Усны сан бүхий газар

59661.8 га буюу 10.8 хувийг -Улсын тусгай хэрэгцээний

газар тус тус эзэлж байна. Эдгээр газрыг өмнөх онтой харьцуулбал хөдөө аж ахуйн газар 0.11 хувиар багасч, хот, тосгон суурин газар 5.9 хувиар, зам, шугам сүлжээний газар 2.7 хувиар нэмэгдсэн байна.

Тайлант жилд нийт газрын 4.2 хувьд хохирол учирсан байна. Газарт учирсан хохирлыг ангилж үзвэл 97.0 хувь нь бэлчээр ба бусад суурин газарт, 2.8 хувь нь хот тосгон бусад суурин газарт, 0.1 хувь нь усны сан бүхий газарт, 0.04 хувь нь ухаж эвдэрсэн газарт тус тус цчирсан нь өмнөх онтой харьцуулбал хохирол учирсан нийт талбай 3.3 пунктээр, бэлчээр ба бусад суурин газар 2.8 пунктээр нэмэгдэж, хот тосгон бусад суурин газар 2.2 пунктээр, усны сан бүхий газар 0.4 пунктээр, ухаж эвдэрсэн газар 0.06 пунктээр буурсан үзүүлэлт гарлаа.

2017 онд нийт газар нутгийн 3.2 хувь буюу 17709.5 га талбайд газар хамгаалах арга хэмжээ авсан нь өмнөх оны мөн үеэс 3.14 пунктээр нэмэгдсэн байна. Газрын төлбөр төлөлт, ноогдуулалтанд 117.5 сая төгрөгийн төлбөр төлөгдсөн нь өмнөх оноос 1.8 хувиар буурсан үзүүлэлттэй гарлаа.

Нийт газар өмчлөгч иргэд 8707 байгааг жилийн эцсийн хүн амтай харьцуулбал 50.0 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 8.4 пунктээр нэмэгдсэн.

## **7. БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГ**

**7.1** 2017-2018 оны хичээлийн жилийн байдлаар аймгийн хэмжээнд төрийн өмчийн 5, хувийн өмчийн 5 нийт 10 цэцэрлэгийн 41 бүлэгт 1800 хүүхэд байгаагаас эмэгтэй 881 хүүхэд хамрагдан хүмүүжиж байна. Цэцэрлэгт хамрагдаж буй хүүхдийн 127 буюу 7.1хувь нь малчдын хүүхэд байна. Цэцэрлэгийн бүлгийг тоогоор нь авч үзвэл яслийн бүлэг 2, бага бүлэг 11, дунд бүлэг 6, ахлах бүлэг 6, бэлтгэл бүлэг 7, холимог бүлэг 4, ээлжийн бүлэг 1, нүүдлийн бүлэг 4 байна. Өмнөх онтой харьцуулбал цэцэрлэгт хамрагдсан хүүхэд 9.0 хувиар, үүнээс эмэгтэй хүүхэд 10.5 хувиар өсч, бүлгийн тоо 16.3 хувиар, малчдын хүүхэд 15.9 хувиар буурсан үзүүлэлт гарлаа.



Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 166 ажиллагсад байгааг өмнөх онтой харьцуулбал 3.1 хувиар нэмэгдсэн байна. эмчийн тоо Өмнөх онтой харьцуулбал эрхлэгч, арга зүйч, бусад ажиллагсад тодорхой хувиар нэмэгдэж, эмч болон туслах багш ижил түвшинд, үндсэн багш 6.4 хувиар буурсан байна.

**7.2** 2017-2018 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 5 сургуулийн 125 бүлэгт 3400 сурагч суралцаж байгаагаас I-V ангийн 61 бүлэгт 1802 сурагч, VI-IX ангийн 44 бүлэгт 1091, X-XII ангийн 20 бүлэгт 507 сурагч суралцаж байна. Ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй 24 сурагч суралцаж, дотуур байранд 149 сурагч амьдарч байна. Өмнөх онтой харьцуулбал бүлгийн тоо 2.5 хувиар, суралцагсад 1.8 хувиар нэмэгдсэн бол дотуур байранд амьдарч буй сурагч 9.7 хувиар, хөгжлийн бэрхшээлтэй суралцагч 14.3 хувиар цөөрсөн байна.

2017-2018 оны хичээлийн жилд 385 хүүхэд 1-р ангид элсэн орсон нь өмнөх хийчээлийн жилээс 4.3 хувиар нэмэгдсэн байна.

Ерөнхий боловсролын сургуульд 291 ажиллагсад байгааг өмнөх онтой харьцуулбал 5.8 хувиар нэмэгдсэн байна. 179 үндсэн багш ажиллаж байгаа ба нэг багшид ногдох суралцагчийн тоо 18.99 байгаа нь. өмнөх оны мөн үеэс 0.49 пунктээр нэмэгдсэн байна. Үндсэн багш болон эмч нарын тоо цөөрч, сургалтын менежер, нийгмийн ажилтан болон бусад ажиллагсдын тоо нэмэгдсэн үзүүлэлт гарлаа.

**7.3** Тайлант онд дуу бүжгийн Боржигон чуулга 43 удаа тоглолт хийж 22.7 мянган үзэгчдэд үйлчилсэн байна. Өмнөх онтой харьцуулбал тоглолтын тоо ижил түвшинд, үзэгчид 7.1 хувиар өслөө. Сумдын соёлын төвүүд 140 арга хэмжээ зохин байгуулж, давхардсан тоогоор 10.4 мянган иргэдийг оролцуулсан нь өмнөх оноос зохиосон арга хэмжээ 13.6 хувиар, арга хэмжээнд оролцогсад 2.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

**7.4** Аймгийн музейн үзмэрийн тоо 771 болж 5.8 мянган үзэгчдэд үйлчилсэн нь өмнөх оноос үзмэрийн тоо 0.9 хувиар, үзэгчид 3 дахин өссөн. Аймгийн хэмжээнд 6 номын сан үйл ажиллагаа явуулж давхардсан тоогоор 40.5 мянган иргэнд үйлчилсэн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал уншигчид 36.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

## **8. ЭРҮҮЛ МЭНД**

Эрүүл мэндийн газрын мэдээгээр 2017 онд 466 эх амаржиж, 2016 онтой харьцуулахад 30 буюу 6.7 хувиар буурсан байна. Амьд төрсөн хүүхэд 418 үүнээс 220 нь хүү, 198 нь охин байна. Өмнөх онтой харьцуулбал амьд төрсөн хүүхэд 32 буюу 7.1 хувиар буурчээ. 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 3 гарсан ба 1000 амьд төрөлтөд 17.2, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 3 ба 1000 амьд төрөлтөд 7.2 хүүхэд тус тус ногдож байна. Эхийн эндэгдэл бүртгэгдээгүй болно.

Тайлант онд 115.9 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оноос 5.1 хувиар, 4.9 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оноос 3.4 хувиар буурсан байна. Халдварт өвчнөөр өвчлөгсөд 234 бүртгэгдсэн нь өмнөх оноос 19.9 хувиар буурсан.

## 9. ГЭМТ ХЭРЭГ

Тайлант онд аймгийн хэмжээнд 171 гэмт хэрэг бүртгэгдсэн ба үйлдэгдсэн гэмт хэргийн 84 буюу 49.1 хувь нь хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг байлаа . Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 7.7 хувиар буурсан байна. Гэмт хэрэгт холбогдогсод 190, үүний 90 буюу 47.4 хувь нь ажилгүй иргэдийн үйлдсэн гэмт хэрэг байна. Гэмт хэрэгт холбогдогсдыг өмнөх онтой харьцуулахад 12.8 хувиар буурсан байна.

Давхардсан тоогоор 759 иргэнийг эрүүлжүүлж, 7 иргэнийг албадан болон сайн дурын эмчилгээнд хамруулсан нь өмнөх оны мөн үеэс эрүүлжүүлсэн иргэний тоо 13.4 хувиар, албадан болон сайн дурын эмчилгээнд хамруулсан иргэний тоо 2.3 хувиар буурсан.

Гэмт хэрэг илрүүлэлт жилийн эцсийн байдлаар 65.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 12.0 пунктээр буурсан байна. Гэмт хэргээс учирсан хохирол 304.0 сая төгрөг, нөхөн төлүүлсэн хохирол 210.0 сая төгрөгт хүрсэн байна.

**ХАВСРАЛТ**

1.1 Хүн ам, сумдаар, хүйсээр, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд		2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Баянтал	Нийт хүн ам	1204	1240	36	103.0
	Эрэгтэй	606	630	24	104.0
	Эмэгтэй	598	610	12	102.0
Сүмбэр	Нийт хүн ам	12352	12710	358	102.9
	Эрэгтэй	6125	6307	182	103.0
	Эмэгтэй	6227	6403	176	102.8
Шивээговь	Нийт хүн ам	3378	3449	71	102.1
	Эрэгтэй	1745	1786	41	102.3
	Эмэгтэй	1633	1663	30	101.8
Бүгд	Нийт хүн ам	16934	17399	465	102.7
	Эрэгтэй	8476	8723	247	102.9
	Эмэгтэй	8458	8676	218	102.6

1.2 Хүн ам, насны бүлгээр, сумдаар, 2017 оны жилийн эцсийн байдлаар

Насны бүлэг	Аймгийн дүн	Сумд		
		Баянтал	Сүмбэр	Шивээговь
0-4.	2335	160	1690	485
5-9.	1998	137	1446	415
10-14.	1378	109	1004	265
15-19	1308	84	994	230
20-24	1350	103	1005	242
25-29	1670	118	1192	360
30-34	1521	93	1087	341
35-39	1250	101	888	261
40-44	1119	84	830	205
45-49	1003	66	745	192
50-54	861	56	626	179
55-59	630	58	457	115
60-64	382	37	277	68
65-69	225	15	171	39
70-74	141	7	112	22
75-79	114	7	86	21
80-84	75	4	65	6
85-89	21	1	18	2
90-94	14	0	13	1
95-99	4	0	4	0
Нийт	17399	1240	12710	3449

1.3 Гадаадад оршин суугаа иргэд, сумдаар, хүйсээр, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд		2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Баянтал	Нийт хүн ам	16	5	-11	31.3
	Эрэгтэй	8	3	-5	37.5
	Эмэгтэй	8	2	-6	25.0
Сүмбэр	Нийт хүн ам	123	141	18	114.6
	Эрэгтэй	60	65	5	108.3
	Эмэгтэй	63	76	13	120.6
Шивээговь	Нийт хүн ам	17	40	23	235.3
	Эрэгтэй	9	20	11	222.2
	Эмэгтэй	8	20	12	250.0
Бүгд	Нийт хүн ам	156	186	30	119.2
	Эрэгтэй	77	88	11	114.3
	Эмэгтэй	79	98	19	124.1

1.4 Өрх, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Нийт өрх				10, түүнээс дээш ам бүлтэй өрх			
	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Баянтал	387	418	31	108.0	0	0	0	0.0
Сүмбэр	3754	3878	124	103.3	12	14	2	116.7
Шивээговь	1048	1068	20	101.9	0	1	1	***
Бүгд	5189	5364	175	103.4	12	15	3	125.0

1.5 Хөдөлмөрийн насны хүн ам, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Хөдөлмөрийн насны хүн ам				Хөдөлмөрийн насны ажиллагчид			
	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Баянтал	727	752	25	103.4	534	532	-2	99.6
Сүмбэр	7472	7499	27	100.4	4058	4059	1	100.0
Шивээговь	2073	2092	19	100.9	1277	1264	-13	99.0
Дүн	10272	10343	71	100.7	5869	5855	-14	99.8

Эх үүсвэр: Сумдаас авсан захиргааны статистик мэдээ

1.6 Халамж үйлчилгээ, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2016 он		2017 он		Хувь	
	Хүний тоо	Олгосон тэтгэвэр, тэтгэмж	Хүний тоо	Олгосон тэтгэвэр, тэтгэмж	Хүний тоо	Олгосон тэтгэвэр, тэтгэмж
Нийгмийн халамжийн сангийн дүн	4724	1259.7	5634	1378.2	119.3	109.4
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1526	814.5	1317	754.0	86.3	92.6
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт тусламж	3198	445.2	4317	624.2	135.0	140.2

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ

1.7 Ердийн хөдөлгөөн, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Амаржсан эх			Төрсөн хүүхэд			Үрчлэгдсэн хүүхэд		
	2016 он	2017 он	Хувь	2016 он	2017 он	Хувь	2016 он	2017 он	Хувь
Баянтал	28	24	85.7	28	24	85.7	1	1	100.0
Сүмбэр	337	285	84.6	341	291	85.3	5	5	100.0
Шивээговь	94	85	90.4	96	85	88.5	1	1	100.0
Дүн	459	394	85.8	465	400	86.0	7	7	100.0

Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээ

1.8 Ердийн хөдөлгөөн, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Бүртгүүлсэн гэр бүл			Цуцалсан гэр бүл			Нас баралт		
	2016 он	2017 он	Хувь	2016 он	2017 он	Хувь	2016 он	2017 он	Хувь
Баянтал	2	6	300.0	1	2		7	3	42.9
Сүмбэр	56	50	89.3	15	25	166.7	84	82	97.6
Шивээговь	23	16	69.6	4	7	175.0	24	15	62.5
Дүн	81	72	88.9	20	34	170.0	115	100	87.0

Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээ

1.9 Шилжилт хөдөлгөөн, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Шилжиж ирсэн				Шилжиж явсан			
	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Баянтал	79	72	-7	91.1	56	62	6	110.7
Сүмбэр	540	447	-93	82.8	530	322	-208	60.8
Шивээговь	126	122	-4	96.8	101	104	3	103.0
Дүн	745	641	-104	86.0	687	488	-199	71.0

Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээ

1.10 Шилжилт хөдөлгөөн, аймаг, нийслэлээр харьцуулсан үзүүлэлтээр

Аймаг, нийслэл	Шилжиж ирсэн				Шилжиж явсан			
	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Улаанбаатар	354	230	-124	65.0	384	101	-283	26.3
Дорноговь	113	101	-12	89.4	98	116	18	118.4
Дундговь	118	81	-37	68.6	48	71	23	147.9
Бусад	160	229			157	200		
Дүн	745	641	-104	86.0	687	488	-199	71.0

Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээ

1.11 Нийгмийн зарим үзүүлэлтүүд, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Бүтэн өнчин хүүхэд				Хагас өнчин хүүхэд			
	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Баянтал	0	0	0	***	10	13	3	130.0
Сүмбэр	21	18	-3	85.7	143	145	2	101.4
Шивээговь	3	3	0	100.0	32	26	-6	81.3
Дүн	24	21	-3	87.5	185	184	-1	99.5

1.12 Нийгмийн зарим үзүүлэлтүүд, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Өрх толгойлсон эцэг, эх				Хөгжлийн бэрхшээлтэй иргэд			
	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Баянтал	54	33	-21	61.1	53	55	2	103.8
Сүмбэр	592	609	17	102.9	466	477	11	102.4
Шивээговь	133	137	4	103.0	164	156	-8	95.1
Дүн	779	779	0	100.0	683	688	5	100.7

1.13 Нийгмийн зарим үзүүлэлтүүд, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Ядуу өрх				Ядуу өрхийн гишүүд			
	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Баянтал	54	34	-20	63.0	214	147	-67	68.7
Сүмбэр	242	255	13	105.4	1072	1108	36	103.4
Шивээговь	82	78	-4	95.1	329	306	-23	93.0
Дүн	378	367	-11	97.1	1615	1561	-54	96.7

Эх үүсвэр: Сумдаас гаргасан захиргааны статистик мэдээ

2.1 Малтай өрх, сумдаар, төрлөөр, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Малтай өрх			Малчин өрх			Мал бүхий өрх		
	2016 он	2017 он	Өөрчлөлт	2016 он	2017 он	Өөрчлөлт	2016 он	2017 он	Өөрчлөлт
Баянтал	157	146	93.0	81	80	98.8	76	66	86.8
Сүмбэр	753	750	99.6	548	543	99.1	205	207	101.0
Шивээговь	145	145	100.0	92	89	96.7	53	56	105.7
Бүгд	1055	1041	98.7	721	712	98.8	334	329	98.5

2.2 Малчид, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Малчид-Бүгд			Үүнээс: Эмэгтэй малчид			Малчид насны бүлгээр, 2017 он		
	2016 он	2017 он	Өөрчлөлт	2016 он	2017 он	Өөрчлөлт	16-34	35-59	60 ба түүнээс дээш
Баянтал	131	130	99.2	61	54	88.5	40	76	13
Сүмбэр	950	891	93.8	420	391	93.1	289	482	120
Шивээговь	150	143	95.3	77	64	83.1	35	86	21
Бүгд	1231	1164	94.6	558	509	91.2	364	644	154

2.3 Малын тоо, сумаар, төрлөөр, 2017 оны жилийн эцсээр

Малын төрөл	Сумд			ДҮН	
	Баянтал	Сүмбэр	Шивээговь		
Адуу		4639	15770	1862	22271
Үхэр		2006	11100	1797	14903
Тэмээ		149	654	126	929
Хонь		32031	151020	22178	205229
Ямаа		27516	145487	22074	195077
Бүгд		66341	324031	48037	438409



#### 2.4 Малын тоо, төрлөөр, харьцуулсан үзүүлэлтээр

Малын төрөл	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Адуу	20250	22271	2021	110.0
Үхэр	13646	14903	1257	109.2
Тэмээ	822	929	107	113.0
Хонь	185883	205229	19346	110.4
Ямаа	177309	195077	17768	110.0
Бүгд	397910	438409	40499	110.2

#### 2.5 Төллөх насны хээлтэгч, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Баянтал	26778	30027	3249	112.1
Сүмбэр	139667	150785	11118	108.0
Шивээговь	19113	20664	1551	108.1
Бүгд	185558	201476	15918	108.6

#### 2.6 Мал төллөлт, сумдаар, 2017 оны жилийн эцсээр

Сумд	Төллөвөл зохих хээлтэгч	Төллөсөн хээлтэгч	Төллөлт	Гарсан төл	Хорогдсон төл	Бойжсон төл	Төл бойжилт
Баянтал	26778	25743	96.1	26321	464	25857	98.2
Сүмбэр	139667	128054	91.7	128577	2337	126240	98.2
Шивээговь	19113	17664	92.4	18156	27	18129	99.9
Бүгд	185558	171461	92.4	173054	2828	170226	98.4

#### 2.7 Төл бойжилт, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Гарсан төл			Хорогдсон төл			Бойжсон төл		
	2016 он	2017 он	Өөрчлөлт	2016 он	2017 он	Өөрчлөлт	2016 он	2017 он	Өөрчлөлт
Баянтал	25340	26321	103.9	1063	464	43.7	24277	25857	106.5
Сүмбэр	118083	128577	108.9	5597	2337	41.8	112486	126240	112.2
Шивээговь	16951	18156	107.1	648	27	4.2	16303	18129	111.2
Бүгд	160374	173054	107.9	7308	2828	38.7	153066	170226	111.2

2.8 Том малын зүй бус хорогдол, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Хорогдсон том мал				Оны эхний малд эзлэх хувь	
	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь	2016 он	2017 он
Баянтал	2481	312	-2169	12.6	4.3	0.5
Сүмбэр	8650	2456	-6194	28.4	3.1	0.8
Шивээговь	3555	122	-3433	3.4	8.1	0.3
Бүгд	14686	2890	-11796	19.7	3.9	0.7

2.9 Эрлийз, нутгийн шилдэг омгийн мал, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Бүгд				Үүнээс: СҮМБЭР хонь			
	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Баянтал	8613	9752	1139	113.2			0	
Сүмбэр	5025	2607	-2418	51.9	1591	1497	-94	94.1
Шивээговь	99	89	-10	89.9			0	
Бүгд	13737	12448	-1289	90.6	1591	1497	-94	94.1

2.10 Тэжээвэр амьтад, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Шувуу				Гахай			
	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Баянтал	50	60	10	120.0	2	0	-2	0.0
Сүмбэр	3732	2921	-811	78.3	254	206	-48	81.1
Шивээговь	11	15	4	136.4	21	35	14	166.7
Бүгд	3793	2996	-797	79.0	277	241	-36	87.0

2.11 Малчдын бэлтгэсэн тэжээл, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Бэлтгэсэн өвс, тн	1672.3	2969.1	1296.8	177.5
Бэлтгэсэн дарш, тн	0.2	18.1	17.9	9050.0
Хужир шүү, тн	316.9	528.1	211.2	166.6

2017 оны бэлтгэсэн өвсөнд худалдаж авсан өвс нэмэгдэж орсон болно.

## 2.12 Газар тариалан, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт		2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Төмс	Тариалсан талбай, га	22.9	17.2	-5.7	75.1
	Хураасан ургац, тн	97.7	100.6	2.9	103.0
Хүнсний ногоо	Тариалсан талбай, га	18.2	17.2	-1	94.5
	Хураасан ургац, тн	117.4	140.7	23.3	119.8
Тэжээлийн ургамал	Тариалсан талбай, га	10.6	4.3	-6.3	40.6
	Хураасан ургац, тн	5.1	27.8	22.7	545.1
Бүгд	Тариалсан талбай, га	51.7	38.7	-13	74.9
	Хураасан ургац, тн	220.2	269.1	48.9	122.2

## 3.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2016 он	2017 он*	Өөрчлөлт	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, сая.төг	47167.4	52206.8	5039.4	110.7
Бүтээгдэхүүн борлуулалт, сая.төг	44862.2	54120.5	9258.3	120.6

## 3.2 ШОНУ-н бүтээгдэхүүн, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2016 он	2017 он*	Өөрчлөлт	Хувь
Бүтээгдэхүүн борлуулалт /үнийн дүнгээр/	сая.төг	42772.1	49245.5	6473.4	115.1
Нүүрс борлуулалт /биет хэмжээ/	мян.тн	1880.3	2023.9	143.6	107.6
Нүүрс гаргалт /үнийн дүнгээр/	сая.төг	45111.2	46879.7	1768.5	103.9
Нүүрс гаргалт /биет хэмжээ/	мян.тн	1961.4	2074.7	113.3	105.8

## 4.1 Төсвийн орлого, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2016 он			2017 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Төлөвлөгөө	Гүйцэтгэл*	
	сая.төг	сая.төг	хувь	сая.төг	сая.төг	хувь
Нийт орлого	15036.3	15701.4	104.4	14718.3	15304.4	104.0
Урсгал орлого	5034.0	5699.1	113.2	5402.1	6176.5	114.3
Татварын орлого	4289.2	4796.9	111.8	4082.2	4691.8	114.9
Татварын бус орлого	744.8	902.2	121.1	1319.9	1484.7	112.5
Тусламжийн орлого	10002.3	10002.3	100.0	9316.2	9127.9	98.0

#### 4.2 Төсвийн зарлага, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2016 он			2017 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Төлөвлөгөө	Гүйцэтгэл*	
	сая.төг	сая.төг	хувь	сая.төг	сая.төг	хувь
Бүх зарлага	16740.1	14687.0	87.7	16809.6	14712.0	87.5
Урсгал зардал	13587.2	12221.1	89.9	14401.5	12924.8	89.7
Хөрөнгийн зардал	3152.9	2465.9	78.2	2408.1	1787.2	74.2
Байгууллагын тоо	47	47	100.0	47	49	104.3
Ажиллагсдын тоо	751	751	100.0	751	783	104.3

#### 4.3 Өглөг, авлага, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Өглөг	27.9	9.6	-18.3	34.4
Авлага	12.3	18.5	6.2	150.4

#### 4.4 Банк, зээл, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	ХЭМЖИХ НЭГЖ	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Салбар үйлчилгээний цэг	тоо	11.0	11.0	0.0	100.0
Цахим банкны үйлчилгээний хэрэглэгчид	хүн	22080	30687	8607.0	139.0
Зээлийн бүтээгдэхүүн	тоо	52	43	-9.0	82.7
Зээл авсан : ААНБ	тоо	20	30	10.0	150.0
Иргэд	хүн	7749	8287	538.0	106.9
Малчид	хүн	546	483	-63.0	88.5
Зээл олгосон : ААНБ	сая.төг	1811.6	1838.9	27.3	101.5
Иргэд	сая.төг	70473.0	86365.6	15892.6	122.6
Үүнээс:Малчид	сая.төг	4435.4	2422.8	-2012.6	54.6
АТМ-н тоо	тоо	11	13	2.0	118.2

Эх үүсвэр: Банкны салбаруудын захиргааны статистик мэдээ

#### 4.5 Бараа, ажил үйлчилгээ, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Төлөвлөгдсөн бараа үйлчилгээ	51	73	22	143.1
Зарлагдсан тендер	51	72	21	141.2
Төлөвлөсөн төсөв /сая.төг/	2066.9	3063.5	996.6	148.2
Гэрээлэгдсэн төсөв /сая.төг/	1832.5	2808.5	976	153.3

Эх үүсвэр: Орон нутгийн өмчийн газрын мэдээ

## 5.1 Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2016 он	2017 он*	Өөрчлөлт	Хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг	7583.7	12133.6	4549.9	113.4
Тэтгэврийн даатгалын сангийн	4747.9	8082.9	3335	107.0
Тэтгэмжийн даатгалын сангийн	527.1	740.4	213.3	123.8
Эрүүл мэндийн даатгалын сангийн	1414.3	2110.4	696.1	120.1
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	736.9	849.0	112.1	139.9
Ажилгүйдлийн даатгалын сангийн	157.5	350.9	193.4	132.6
Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая.төг	9385.3	11257.7	1872.4	109.1
Тэтгэврийн даатгалын сангийн	6781.5	7513.1	731.6	110.3
Тэтгэмжийн даатгалын сангийн	569.5	719.2	149.7	96.2
Эрүүл мэндийн даатгалын сангийн	1527.6	1917.7	390.1	113.2
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	287.5	779.8	492.3	92.0
Ажилгүйдлийн даатгалын сангийн	219.2	327.9	108.7	109.3

Эх үүсвэр: Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн мэдээ

## 5.2 Даатгал, нөхөн төлбөр, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2016 он		2017 он		Өөрчлөлт		Хувь	
	Орлого /мян.төг/	Олгосон нөхөн төлбөр /мян.төг/	Орлого /мян.төг/	Олгосон нөхөн төлбөр /мян.төг/	Орлого /мян.төг/	Олгосон нөхөн төлбөр /мян.төг/	Орлого	Олгосон нөхөн төлбөр
Тээврийн хэрэгслийн даатгал	28459.0	31705.2	43672.9	9414.9	15213.9	-22290.3	153.5	29.7
Жолоочийн хариуцлагын даатгал	108578.0	19163.0	87103.3	19679.4	-21474.7	516.4	80.2	102.7
Эд хөрөнгийн даатгал	1241.0	0.0	555.8	0.0	-685.2	0.0	44.8	***
Хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгал	17971.2	12398.0	16025.6	14679.0	-1945.6	2281.0	89.2	118.4
Гэнэтийн ослын даатгал	20791.0	2424.0	10076.0	3016.0	-10715.0	592.0	48.5	124.4
Хүүхдийн гэнэтийн ослын даатгал	2244.0	271.2	1748.0	1340.0	-496.0	1068.8	77.9	494.1
Гадаад зорчигчдын даатгал	148.4	0.0	351.4	0.0	203.0	0.0	236.8	***
Мэргэжлийн хариуцлагын даатгал	1062.8	2380.0	847.2	0.0	-215.6	-2380.0	79.7	***
Ачаа тээвэрлэлтийн даатгал	2803.4	0.0	16496.3	0.0	13692.9	0.0	588.4	***
Гэр хашаа байшингийн даатгал	375.0	127.0	420.0	0.0	45.0	-127.0	***	***
Нийтийн ба хувийн орон сууцны даатгал	0.0	0.0	120.0	0.0	120.0	0.0	***	***
Лангуу түрээслэгч, жижиглэн худалдаа эрхлэгчдийн даатгал	0.0	0.0	288.9	0.0	288.9	0.0	***	***
Электрон тоног төхөөрөмжийн даатгал	0.0	0.0	267.2	0.0	267.2	0.0	***	***
Бүтээгдэхүүн хариуцлагын даатгал	0.0	0.0	1000.0	0.0	1000.0	0.0	***	***
Дүн	183673.8	68468.4	178972.6	48129.3	-4701.2	-20339.1	97.4	70.3
Банкны зуучлалаар хийгдсэн даатгал	28539.6	323.3	31235.8	414.0	2696.2	90.7	109.4	128.1
Бүгд	212213.4	68791.7	210208.4	48543.3	-2005.0	-20248.4	99.1	70.6

Эх үүсвэр: Даатгалын салбаруудын захиргааны статистик мэдээ

### 6.1 Тээвэр зуучлал, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	хэмжих нэгж	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Зорчигч эргэлт	мян.хүн.км	5355.2	5456.6	101.4	101.9
Тээвэрлэсэн зорчигч	мян.хүн	23.9	25.3	1.4	106.0
Тээврийн орлого	мян.төг	14200.0	15439.4	1239.4	108.7
Ажиллагчдын тоо	хүн	11	11	0.0	100.0

### 6.2 Тээврийн хэрэгсэл, харьцуулсан үзүүлэлтээр

Төрөл	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Суудлын автомашин	1759	2135	376	121.4
Ачааны автомашин	838	817	-21	97.5
Хоёр дугуйт	207	269	62	130.0
Бусад	243	284	41	116.9
Бүгд	3047	3505	458	115.0

Эх үүсвэр: Тээвэр зохицуулалтын газрын захиргааны статистик мэдээ

### 6.3 Харилцаа холбоо, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	ХЭМЖИХ НЭГЖ	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Нийт орлого	мян.төг	202478.0	156237.7	-46240.3	77.2
Үүнээс: Хүн амаас	мян.төг	121583.6	93739.5	-27844.1	77.1
Телефон цэг	тоо	334	285	-49.0	85.3
Ажиллагчдын тоо	хүн	13	13	0.0	100.0

### 6.4 Газрын нэгдмэл сан, харьцуулсан үзүүлэлтээр

Газрын ангилал	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Нийт газар, га	554180.0	554180.0	0	100.00
Хөдөө аж ахуйн газар	481694.0	481186.6	-507.4	99.89
Хот, тосгон бусад суурин газар	6168.6	6537.2	368.6	105.98
Зам, шугам сүлжээний газар	5117.6	5256.4	138.8	102.71
Усны сан бүхий газар	1538.0	1538.0	0	100.00
Улсын тусгай хэрэгцээний газар	59661.8	59661.8	0	100.00

Эх үүсвэр: Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэдээ

## 6.5 Газарт учирсан хохирол, хувиар, харьцуулсан үзүүлэлтээр

Газрын ангилал	2016 он	2017 он	Өөрчлөлт, пункт
Хохирол учирсан талбайн нийт газарт эзлэх хувь	0.9	4.2	3.3
Хохирол учирсан талбай	100.0	100.0	0
Бэлчээр ба бусад суурин газарт	94.2	97.0	2.8
Хот, тосгон бусад суурин газарт	5.0	2.8	-2.2
Үүнээс: Усны сан бүхий газар	0.7	0.1	-0.6
Ухаж эвдэрсэн газарт	0.1	0.04	-0.06

Эх үүсвэр: Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэдээ

## 7.1 Сургуулийн өмнөх боловсролын бүлэг, хамрагдалт, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2016-2017	2017-2018	Өөрчлөлт	Хувь
Нийт цэцэрлэг	9	10	1	111.1
Төрийн	5	5	0	100.0
Хувийн	4	5	1	125.0
Цэцэрлэгт хамрагдсан хүүхэд	1652	1800	148	109.0
Эмэгтэй хүүхэд	797	881	84	110.5
Малчдын хүүхэд	151	127	-24	84.1
Цэцэрлэгийн бүлэг	49	41	-8	83.7
Яслийн бүлэг	0	2	2	***
Бага бүлэг	12	11	-1	91.7
Дунд бүлэг	10	6	-4	60.0
Ахлах бүлэг	8	6	-2	75.0
Бэлтгэл бүлэг	10	7	-3	70.0
Холимог бүлэг	3	4	1	133.3
Ээлжийн бүлэг	1	1	0	100.0
Нүүдлийн бүлэг	5	4	-1	80.0

Эх үүсвэр: Боловсрол, соёл урлагийн газрын мэдээ

## 7.2 Сургуулийн өмнөх боловсролд ажиллагсад, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2016-2017	2017-2018	Өөрчлөлт	Хувь
Нийт ажиллагсад	161	166	5	103.1
Эрхлэгч	9	10	1	111.1
Арга зүйч	1	2	1	200.0
Үндсэн багш	47	44	-3	93.6
Туслах багш	42	42	0	100.0
Эмч	2	2	0	100.0
Бусад ажиллагсад	60	66	6	110.0

Эх үүсвэр: Боловсрол, соёл урлагийн газрын мэдээ

### 7.3 Ерөнхий боловсролын сургуулийн бүлэг, хамрагдалт, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2016-2017	2017-2018	Өөрчлөлт	Хувь
Нийт сургууль	5	5	0	100.0
Нийт сураглцагсад	3340	3400	60	101.8
Эмэгтэй	1717	1715	-2	99.9
Малчдын хүүхэд	552	535	-17	96.9
Сургуулийн бүлэг	122	125	3	102.5
1-5 дугаар анги				
бүлэг	60	61	1	101.7
суралцагсад	1740	1802	62	103.6
6-9 дүгээр анги				
бүлэг	40	44	4	110.0
суралцагсад	1026	1091	65	106.3
10-12 дугаар анги				
бүлэг	22	20	-2	90.9
суралцагсад	574	507	-67	88.3
<u>Дотуур байранд амьдарч буй хүүхэд</u>	<u>165</u>	<u>149</u>	<u>-16</u>	<u>90.3</u>

Эх үүсвэр: Боловсрол, соёл урлагийн газрын мэдээ

### 7.4 Ерөнхий боловсролын сургуульд ажиллагсад, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2016-2017	2017-2018	Өөрчлөлт	Хувь
Нийт ажиллагсад	275	291	1	105.8
Захирал	5	5	0	100.0
Сургалтын менежер	9	10	1	111.1
Нийгмийн ажилтан	4	5	1	125.0
Үндсэн багш	181	179	-2	98.9
Эмч	5	3	-2	60.0
Бусад ажиллагсад	71	89	18	125.4

Эх үүсвэр: Боловсрол, соёл урлагийн газрын мэдээ



7.5 Соёл, урлагийн байгууллагуудын мэдээ, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	хн	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Чуулга	тоо	1	1	0	100.0
Тоглолт	тоо	43	43	0	100.0
Үзэгчид	мян.хүн	21.2	22.7	1.5	107.1
Урын санд байгаа бүтээл	тоо	30	36	6	120.0
Музей	тоо	1	1	0	100.0
Үзмэр	тоо	764	771	7	100.9
Үзэгчид	мян.хүн	1.9	5.8	3.9	305.3
Тухайн жилд нэмсэн үзмэр	тоо	7	7	0	100.0
Номын сан	тоо	1	1	0	100.0
Суудал	тоо	50	50	0	100.0
Уншигчид	мян.хүн	25.0	31.6	6.6	126.4
Номын фонд	мян.ш	7.5	8.4	0.9	112.0
Сургуулийн номын сан	тоо	5	5	0	100.0
Суудал	тоо	129	129	0	100.0
Уншигчид	мян.хүн	4.7	8.9	4.2	189.4
Номын фонд	мян.ш	46.1	41.9	-4.2	90.9
Соёлын төв	тоо	2	2	0	100.0
Суудал	тоо	300	300	0	100.0
Зохион байгуулсан хэмжээ	арга тоо	162	140	-22	86.4
Зохион байгуулсан хэмжээнд оролцогсод	арга мян.хүн	10.7	10.4	-0.3	97.2

Эх үүсвэр: Боловсрол, соёл урлагийн газрын мэдээ

8.1 Эрүүл мэндийн статистик, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Төрсөн эх	446	416	-30	93.3
Амьд төрсөн хүүхэд	450	418	-32	92.9
Амьгүй төрсөн хүүхэд	2	2	0	100.0
Нялхсын эндэгдэл	7	3	-4	42.9
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	3	1	150.0
Нийт нас баралт	73	91	18	124.7
Эмнэлгийн нас баралт	14	7	-7	50.0
Эмчлэгдсэн өвчтөн	5023	4852	-171	96.6
Түргэн тусламжийн дуудлага	6927	6563	-364	94.7
Амбулаторын үзлэг	122060	115870	-6190	94.9
Халдварт өвчин	292	234	-58	80.1

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газрын мэдээ

9.1 Гэмт хэргийн статистик, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг	91	84	-7	92.3
Хүүхэд гэр бүлийн нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	7	4	-3	57.1
Иргэдийн улс төрийн болон эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	1	0	-1	***
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	73	56	-17	76.7
Аж ахуйн эсрэг гэмт хэрэг	1	0	-1	***
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	9	3	-6	33.3
Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	8	1	-7	12.5
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	13	20	7	153.8
Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	0	2	2	***
Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	2	1	-1	50.0
Албан тушаалын гэмт хэрэг	2	0	-2	***
Бүгд	207	171	-36	82.6

Эх үүсвэр: Цагдаагийн хэлтсийн мэдээ





